

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРӨӨС  
ДҮҮРЭГ ХАРИУЦАН ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

2024 оны 12 дугаар сарын 16

Улаанбаатар хот

| д/д                                                                                                                                                                                                                              | Шалгуур үзүүлэлт                                                                                                   | Хэмжих нэгж | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага | Суурь түвшин (2020)          | Зорилтот түвшин                                                                            | Хүрсэн түвшин                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      | Хэрэгжилт хувь |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------|---------------------------------|------------------------------|--------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------|
| 1                                                                                                                                                                                                                                | 2                                                                                                                  | 3           | 4                               | 5                            | 6                                                                                          | 7                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  | 8              |
| 5.1.Ногоон хөгжил. Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ. |                                                                                                                    |             |                                 |                              |                                                                                            |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                    |                |
| 1                                                                                                                                                                                                                                | 5.1.4.Гэр хороолол болон аялал жуулчлалын бүсэд “Эко жорлон” арга хэмжээг хэрэгжүүлж, хөрсний бохирдлыг бууруулна. | Тоо         | Барилга, хот байгуулалтын яам   | 2022-2024 он дамжин хэрэгжих | Нийт 950 гаруй айл өрхийн нүхэн жорлонг стандартад нийцсэн ариун цэврийн байгууламж болгох | Хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022-2023 онд нийт 1.1 тэрбум төгрөгөөр ариутгах татуургын шугам сүлжээнд холбогдоогүй гэр хорооллын айл өрхүүдийн нүхэн жорлонг сайжруулан ажиллаж байна. Үүнд: Чингэлтэй дүүргийн 7, 17, 18, 19 дүгээр хороодын нийт 400 айл өрхийн нүхэн жорлонг шинэчлэхээр нүхийг ухаж бэлтгэсэн боловч кольцо суурилуулах ажил тодорхойгүй хугацаагаар хойшлоод байна. Мөн Барилга, хот байгуулалтын яамнаас Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023-2024 онд он дамжин нийт 4.4 тэрбум төгрөгөөр, ариутгах татуургын шугам сүлжээнд холбогдоогүй гэр хорооллын айл өрхүүдийн нүхэн жорлонг сайжруулах, айл өрхийн байшингийн дулаалга хийх цогц ажлыг хэрэгжүүлээд байна. Үүнд: Чингэлтэй дүүргийн 7, 12-19 дүгээр хороодын нийт 150 айл өрх | 70             |

|   |                                                                                                                                                                                                                                     |     |                                      |                              |                                                                                    |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |    |
|---|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----|--------------------------------------|------------------------------|------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
|   |                                                                                                                                                                                                                                     |     |                                      |                              |                                                                                    | хамрагдаж 2023 оны 08 дугаар сард бүрэн дуусаж, Улсын комисс хүлээн авсан. Барилга, хот байгуулалтын яамнаас дүүргийн нутаг дэвсгэрт 2023-2024 онд он дамжин хэрэгжиж буй “ЭКО ЖОРЛОН” ажлын хүрээнд “Дархан нэгдэл” ХХК нь дүүргийн 7, 10, 12-17, 19 гэсэн нийт 9 хороонд 450 эко жорлон хийхээр төлөвлөснөөс төсөвт өртгийн 50% буюу 890.169.016 төгрөгийн санхүүжилт авч 260 ширхэг эко жорлон тавьсан. 2023 онд БХБЯ-нд санхүүжилтийн хүсэлт гаргасны дагуу 2024 онд санхүүжилт бүрэн тавигдсан бөгөөд гэрээний хугацаа дуусахаас өмнө хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. |    |
| 2 | 5.1.11.“Хөх морь” төслийн хүрээнд гадаргын усны хуримтлал бий болгон усан хангамжийг нэмэгдүүлэх Орхон-Онги, Хэрлэн-Тоонот төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулан төслийн байгууламжийн ажлыг эхлүүлнэ. | Тоо | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар | 2022-2023 он дамжин хэрэгжих | Сервис центрийн бохирын байгууламжаас гарах саарал усыг цуглуулах цөөрөм байгуулах | Улсын төсвийн хөрөнгөөр дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “Сервис центрийн бохирын байгууламжаас гарах саарал усыг цуглуулах цөөрөм” төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр “Төрөлхмөрөн” ХХК шалгарч, ажлын зураг төслийг боловсруулан Барилгын хөгжлийн төвд магадлалын дүгнэлтээр баталгаажуулж, авто замын доогуурх сүвэлгээ, 65 у/м шугам хоолойн сувагчлалын ажлыг хийж гүйцэтгэсэн.                                                                                                                                                                      | 70 |
|   |                                                                                                                                                                                                                                     |     |                                      |                              |                                                                                    |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |    |

6.1.Улаанбаатар болон дагуул хотыг орон зайн оновчтой төлөвлөлт, ухаалаг шийдэл, амьдралын таатай орчин бүхий ногоон хот болгож хөгжүүлнэ.

|   |                                                                                                                                                                                                        |     |                                      |                   |                           |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |    |
|---|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----|--------------------------------------|-------------------|---------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| 3 | 6.1.7 Олон улсын стандартад нийцсэн явган хүний болон унадаг дугуйн зам, хүүхдийн тоглоомын талбай, ногоон байгууламж барьж байгуулан, тоосжилтыг 50 хувь бууруулна.                                   | км  | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар | 5,8 км дугуйн зам | 0,7 км дугуйн зам         | Нийслэлийн Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй дүүргүүдэд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ “Унадаг дугуйн замын ажил” (Чингэлтэй дүүргийн Гэсэр сүмийн уулзвараас Анкарагийн гудамж хүртэлх 0.7 км дугуйн замын ажил) /Багц-2/-ын тендер сонгон шалгаруулалтад “Драгон бридж” ХХК шалгарч гэрээ байгуулсан боловч 2022 онд гэрээ нь цуцлагдаж ажил зогссон.                                                                       | -  |
|   |                                                                                                                                                                                                        | м2  | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар | 2186 м2 явган зам | 4500 м2 явган зам         | Нийслэлээс 2024 оныг “Тохижилт-Бүтээн байгуулалтын жил” болгон зарласны хүрээнд дүүргийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 4 байршилд тоглоомын талбай сэргээн засварласан. Мөн дүүргийн хэмжээнд 136 у/км явган зам байдаг бөгөөд орон нутгийн төсвийн 900.0 сая төгрөгөөр 15 байршил (1, 4, 6, 7, 10, 12, 16, 18, 20 дугаар хороо)-д 4500 м2 явган зам, 11 байршилд гудамж сайжруулах ажлуудыг тус тус хийж гүйцэтгэсэн.                 | 70 |
| 4 | 6.1.8 Улаанбаатар хотын ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлж, дүүрэг бүрд цэцэрлэгт хүрээлэн байгуулна. Туул, Сэлбэ, Дунд голын урсцын тохируулга хийж, голуудын орчинд олон нийтийн соёл, амралтын | Тоо | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар | 1                 | 1 дүүрэгт төсөл хэрэгжсэн | Улсын төсвийн 5 тэрбум төгрөгийн хөрөнгөөр дүүргийн 19 дүгээр хороо, тахилтын аманд тохижилтын ажил хийж гүйцэтгэхээр зураг төсвийг “Сивил дизайн” ХХК гүйцэтгэсэн бөгөөд тендер сонгон шалгаруулалтаар ажлын гүйцэтгэгчээр “Жавхлант хүслэн” ХХК шалгарч гэрээ байгуулан шат, явган зам, ногоон байгууламжийн ажлыг хийж гүйцэтгэж буй бөгөөд одоогийн байдлаар усны хаялгын шуудуу, цахилгааны утас, шат зэрэг ажлуудыг хийж гүйцэтгээд байна. | 70 |
|   |                                                                                                                                                                                                        | Тоо | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар | -                 | 1 цэцэрлэгт хүрээлэн      | Нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангийн 800.0 сая төгрөгийн төсөвт өртгөөр дүүргийн 19 хороо, зуслангийн бүс буюу “Хайрхан хөгжлийн төв” ОНӨТҮГ орчимд амралтын                                                                                                                                                                                                                                                                                 | 70 |

|                   |                           |  |  |  |  |                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |     |
|-------------------|---------------------------|--|--|--|--|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----|
|                   | тохилог орчныг бүрдүүлнэ. |  |  |  |  | талбай, хүүхдийн тоглоомын талбай, явган зам, шат, пандус, хогийн сав, гэрэлтүүлэг, сүүдрэвч, ногоон байгууламж зэрэг тохижилт, бүтээн байгуулалтын ажил хийхээр төлөвлөж, зураг төсөв боловсруулах ажлын даалгавар нь 2024 оны 03 дугаар 28-ны өдөр батлагдаж, тендер сонгон шалгаруулалтыг зарлаж, гүйцэтгэгч шалгаран гэрээ байгуулагдсан байна. |     |
| Үнэлгээний дундаж |                           |  |  |  |  |                                                                                                                                                                                                                                                                                                                                                     | 70% |